



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/02/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ  
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: [bayanjargalg@audit.gov.mn](mailto:bayanjargalg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	11
3.5.2 Авлага .....	12
3.5.3 Урьдчилгаа.....	13
3.5.4 Бараа материал.....	13
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө.....	14
3.5.6 Үндсэн хөрөнгө.....	14
3.5.7 Өр төлбөр.....	14
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо .....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	19
4.1 Ерөнхий зүйл .....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	20
4.5.1 Завсрын аудитын талаар .....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	21
5.1 Төлбөрийн акт .....	22
5.2 Албан шаардлага .....	22
5.3 Зөвлөмж .....	22
6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл.....	24
7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	24
7.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	24
7.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	24
7.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	25

### ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс хөдөө аж ахуйн газар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЭЭС	Эмийн эргэлтийн сан

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 04/230.  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА Б.БАТЖАРГАЛ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Аргалант сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 чиг үүргийн 43 зорилтын хүрээнд 116 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн "Сумдын 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнгийн тухай" А/104 тоот захирамжаар үр дүнтэй хэрэгжсэн 62 арга хэмжээ, тодорхой үр дүнд хүрсэн 48 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 13 арга хэмжээг 85.99 хувиар биелүүлж, "В" үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Орон нутгийн хамгаалалтад байдаг 6 түүх дурсгалын газрын координатыг тогтоолгож, кадастрын зураг хийлгэн гэрээгээр эзэнжүүлж цахим болон цаасан баримт үүсгэсэн байна.

### Аудитын гол асуудал

Сумын хоршоо хөгжүүлэх сангаас 2023 оны 4 дүгээр сард 4 иргэнд 160,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байна.

G/Архив/Албан бичиг 2024/ А4

610900521

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан төрийн албан хаагчдын орон сууцжуулах хөтөлбөрт 100,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 80,000.0 мянган төгрөгийг гэрээний дагуу иргэнд шилжүүлж, сумын орон нутгийн хөгжлийн сангаас наадмын талбайг тохижуулах ажлын тендер зарлагдаж Флай Хай ХХК тендерт шалгарч тайлант онд явцын санхүүжилтэд 56,800.0 мянган төгрөгийг шилжүүлж авлагаар тусгасан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		903,223.5	1,220,331.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	462,776.3	604,825.1
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	326,584.4	498,844.1
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	113,862.8	116,662.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,537,847.6	2,450,632.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,537,847.6	2,450,632.3
39200	Биет хөрөнгө		1,884,658.9	1,797,946.0
39300	Биет бус хөрөнгө	13	653,188.7	652,686.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		3,441,071.1	3,670,963.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		5,149.6	11,046.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	5,149.6	11,046.1
41300	Өглөг	17а, 17б	5,149.6	11,046.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,435,921.5	3,659,917.8
51	Засгийн газрын хувь оролцоо		3,435,921.5	3,659,917.8
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,385,745.2	1,385,745.2
51200	Хуримтлагдсан үр дүн		1,907,704.5	2,131,700.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		142,471.8	142,471.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		3,441,071.1	3,670,963.9

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		1,277,343.6	1,599,965.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО		404,285.7	630,719.6
110	Орлогын албан татвар		257,721.3	444,530.8
1100	Хувь хүний орлогын албан татвар		273,057.8	461,530.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-15,336.5	-17,000.0
113	Хөрөнгийн албан татвар		86,889.2	101,721.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж		59,675.1	84,467.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	350,018.8	199,720.2
120	Нийтлэг татварын бус орлого		350,018.8	199,720.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		523,039.2	769,525.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	935,440.0	1,365,356.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ		881,373.2	1,240,281.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		875,978.6	1,234,830.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		250,572.6	423,140.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		32,244.0	55,977.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		270,515.6	89,836.2
2104	Хангамж, бараа материалын зардал		27,641.1	41,257.9
2105	Нормативт зардал		75,317.0	64,753.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		5,350.0	5,474.1
2107	Томиллолт, зочны зардал		3,118.3	5,748.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		23,401.2	4,777.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		187,818.7	543,865.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,394.6	5,451.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		54,066.8	125,074.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		341,903.7	234,609.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,487,948.4	854.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-2,146,044.8	233,754.9

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	1,185,235.9	1,641,706.7
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	404,285.7	630,719.6
110	Орлогын албан татвар	257,721.3	444,530.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	273,057.8	461,530.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-15,336.5	-17,000.0
113	Хөрөнгийн албан татвар	86,889.2	101,721.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	59,675.1	84,467.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,611.8	7,341.2
1181	Газрын төлбөр	53,556.3	77,126.0
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	257,911.0	241,461.4
120	Нийтлэг татварын бус орлого	257,911.0	241,461.4
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	523,039.2	769,525.7
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	755,485.9	1,100,629.5
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	755,485.9	1,100,629.5
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	737,423.0	1,095,178.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	251,879.3	425,679.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,970.4	53,432.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	270,459.4	89,423.7
2104	Хангамж, бараа материалын зардал	12,503.6	17,071.2
2105	Нормативт зардал	90,310.3	57,850.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,350.0	2,350.0
2107	Томилолт, зочны зардал	3,218.3	5,748.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,956.0	7,879.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,775.7	435,743.8
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	18,062.9	5,451.5
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	429,750.0	541,077.2
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	236,084.7	237,933.9
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	236,084.7	237,933.9
2200	Дотоод эх үүсвэрээр	236,084.7	237,933.9
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	-236,084.7	-237,933.9
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-100.0	-161,094.5
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	100.0	161,094.5
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	193,565.3	142,048.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	269,211.0	462,776.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	462,776.3	604,825.1

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,112,674.9	1,271,666.6	1,522,735.9	5,907,077.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,726,929.7	-1,129,194.8	2,531,013.4	-325,111.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,385,745.2	142,471.8	4,053,749.3	5,581,966.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-2,146,044.8	-2,146,044.8
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,385,745.2	142,471.8	1,907,704.5	3,435,921.6
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,385,745.2	142,471.8	1,907,704.5	3,435,921.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	-9,758.6	-9,758.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,385,745.2	142,471.8	1,897,945.9	3,426,163.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	233,754.9	233,754.9
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,385,745.2	142,471.8	2,131,700.8	3,659,917.8

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,629,685.3</b>	<b>1,293,296.4</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	921,267.7	901,257.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	919,267.7	899,267.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	394,779.4	391,437.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,347.5	48,946.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	420,905.5	409,128.4
2104	Хангамж, бараа материалын зардал	17,366.3	16,510.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,450.0	7,450.0
2107	Томилолт, зочны зардал	6,094.7	5,748.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,824.3	7,556.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,500.0	12,489.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000.0	1,990.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000.0	1,990.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	482,063.9	230,944.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	226,353.7	161,094.5
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,629,685.3</b>	<b>1,338,792.7</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	173,969.8	169,614.7
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	957,619.8	1,094,329.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	498,095.7	74,848.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	124,195.6	184,557.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	184,557.4	230,053.8
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	24
620001	Удирдах ажилтан	7	7
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	4	4

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	30,033.9	161,587.5
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	30,033.9	161,587.5
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	16,843.4	137,665.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0	34,241.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0	4,485.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300.0	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,517.1	98,377.2
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	13,190.5	23,922.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,380.0	0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,810.5	23,922.2
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	29,944.2	161,587.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,944.2	161,587.5
III	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	(89.7)	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	89.7	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Аргалант сумын Засаг дарга Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Аргалант сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай “Түүхт ой-бүтээн байгуулалт” урианы жилийн төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэхээр байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 чиг үүргийн 43 зорилтын хүрээнд 116 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсныг 85.99%-тай биелүүлж, “В” үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Аргалант сумын 2 төсөвт байгууллагад удирдах 8, гүйцэтгэх 9, үйлчилгээний 78, нийт 95 орон тоотой баталж, гүйцэтгэлээр 87 орон тоотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Аргалант сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг

зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод хяналтын төлөвлөгөөг 2023 онд нийт 12 ажил үүрэг гүйцэтгэхээр төлөвлөн батлуулсан. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Аргалант сумын Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан 90,0 хувьтай шаардлага бүрэн хангасан, эмийн эргэлтийн сан эрсдэлтэй багатай гэж дүгнэгдэж санхүү тасгийн үйл ажиллагаа өгсөн үүрэг даалгавар зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөөг гарган хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Аргалант сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдаж байгаа байгууллагаас ЗДТГ хязгаарлалттай дүгнэлт авч, ИТХ, эмийн эргэлтийн сан, орон нутгийн хөгжлийн сан, хоршоо хөгжүүлэх сан түүвэрт хамрагдсан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 229,892.8 мянган төгрөгөөр буюу 6,7 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	462,776.3	604,825.1	142,048.8
Авлага	326,584.4	498,844.1	172,259.7
Бараа материал	113,862.8	116,662.4	2,799.7
Үндсэн хөрөнгө	2,537,847.6	2,450,632.3	-87,215.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,441,071.1</b>	<b>3,670,963.9</b>	<b>229,892.8</b>
Өр төлбөр	5,149.6	11,046.1	5,896.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,435,921.5	3,659,917.8	223,996.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,441,071.1</b>	<b>3,670,963.9</b>	<b>229,892.8</b>

Эх сурвалж: Аргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 604,825.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 142,048.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь Орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэл 355,718.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 85,044.2 мянган төгрөгөөр өссөн, мөн хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 86,245.9 мянган төгрөгөөр буурч, Орон нутгийн хөгжлийн сан 131,742.3 мянган төгрөгөөр өссөн, эмийн эргэлтийн сан 8,839.9 мянган төгрөгөөр өссөн, Аргалант илч ОНӨААТҮГ-ын арилжааны банкин дахь дансны үлдэгдэл 2,668.4 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 498,844.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 172,259.7 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх ажил бүрэн хийгдэж дуусаагүй 56,800.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэснээс авлага 30,874.5 мянган төгрөгөөр өссөн, ЗДТГ-ын авлага 57,936.4 мянган төгрөгөөр өссөн (нэмэлт санхүүжилтийн дансанд орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэхээр 80,000.0 мянган төгрөг, ажил хүлээлцэх комисс хүлээж аваагүй ажлын 29,040.5 мянган төгрөгийн авлагатай), Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 онд 160,000.0 мянган төгрөгийн зээл олгосон тул авлага 82,330.0 мянган төгрөгөөр өссөн, эмийн эргэлтийн сангийн дутагдуулсан эмийн тооцоогоор үүсгэсэн 48,087.9 мянган төгрөгөөр авлага үүсгэснээс 1,118.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 116,662.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,799.7 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-н аж ахуйн материал болон бусад хангамжийн материал 8,228.5 мянган төгрөгөөр өсөж, эмийн эргэлтийн сангийн бараа материалын үлдэгдэл 5,203.0 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,450,632.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 87,215.3 мянган төгрөгөөр буурсан нь шилжих үлдэгдлээс ЗДТГ-т 48,222.0 мянган төгрөгөөр, ИТХ-д 2,292.1 мянган төгрөгөөр, Эмийн эргэлтийн санд 6,989.5 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэж, худалдан авсан боловч тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардал 190,032.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 11,046.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,896.5 мянган төгрөгөөр өссөн нь Ерөнхий боловсролын сургуулийн гэрэл цахилгааны өглөг 3,555.7 мянган төгрөгөөр, ЗДТГ-ын нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 65.5 мянган төгрөгөөр, гэрэл цахилгааны зардлын өглөг 1,082.6 мянган төгрөгөөр, ИТХ-н нийгмийн даатгалын өглөг 1,073.6 мянган төгрөгөөр, эмийн эргэлтийн сангийн байгууллагад төлөх өглөг 119.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 3,659,917.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 223,996.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 233,754.9 мянган төгрөгөөр өссөнөөр шалтгаалсан байна.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 604,825.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 142,048.8 мянган төгрөгөөр өссөн байна.

#### Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	462,776.3	604,825.1	142,048.8
Төгрөг	462,776.3	604,825.1	142,048.8
Төрийн сангийн харилцах	455,231.6	585,772.1	130,540.6
Арилжааны банк дахь харилцах	7,544.7	19,053.0	11,508.2
<b>Дүн</b>	<b>462,776.3</b>	<b>604,825.1</b>	<b>142,048.8</b>

Эх сурвалж: Аргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн тодруулга

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 585,772.1 мянган төгрөгийн 60,7 хувь буюу 355,718.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий орлогын, 24,2 хувь буюу 141,531.0 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 15,1 хувь буюу 88,522.8 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 16,374.4 мянган төгрөг, Аргалант илч ОНӨААТҮГ-ын 2,678.6 мянган төгрөг арилжааны банканд байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 142,048.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Орон нутгийн төсвийн ерөнхий орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, өмнөх оноос 85,044.3 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 131,742.3 мянган төгрөгөөр тус тус өссөн бөгөөд хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 86,246.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Арилжааны банкин дахь оны эхний үлдэгдэл дээр Аргалант илч ОНӨААТҮГ-ын харилцахын үлдэгдэл 2,668.4 мянган төгрөгөөр, эмийн эргэлтийн сангийн харилцахын үлдэгдэл 8,839.9 мянган төгрөгөөр өсөж, нийтдээ 11,518.4 мянган төгрөгөөр өссөн байна.

**Аудитын илрүүлэлт:** Сумын ЗДТГ, ИТХ-ын санхүүгийн тайланд Аймгийн засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны Б/02 тоот захирамжаар сумын засаг даргад, сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны А/01 тоот захирамжаар засаг даргын орлогчид, тодорхой шийдвэргүйгээр 2 багийн засаг дарга нарт орон нутгийн нэмэгдэл цалин олгосон нийт 7,932.0 мянган төгрөгийн, сумын ИТХ-ын даргын 2023 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийг хуралдааны Б/01 захирамжаар орон нутгийн нэмэгдэлд 2,276.6 мянган төгрөгийн, төрийн алба хаасны нэмэгдэлд 244.9 мянган төгрөгийн, нийт 2,521.5 мянган төгрөгийн цалин олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоож шийдвэрлэлээ.

Сумын ЗДТГ нь харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг цахим баримтаар баталгаажуулаагүй 4.325,5 мянган төгрөгийн, Дэмжих анхан шатны баримтгүй, үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж баталгаажуулаагүй, зарцуулалтын тайлангүй 7,174.6 мянган төгрөгийн, Шилжих үлдэгдлийн эх үүсвэртэй Хөрөнгийн зардлаас хөрөнгө оруулалтын шинжгүй зардалд зарцуулсан 21,890.4 мянган төгрөгийн, Ногоон тэжээл худалдан авахаар Марс арвай ХХК-тай гэрээ байгуулж, төлбөр тооцоо хийхдээ хувь хүнд шилжүүлсэн 4,046.0 мянган төгрөгийн, сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 14-ний Б/26 тоот захирамжаар төсвийг зохистой удирдаагүй, авлага, өр төлбөр үүсгэн төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй ажилласан Тамгын газрын даргад 12 дугаар сард 2 дахь удаа мөнгөн урамшуулалд 638.8 мянган төгрөгийг олгосон зөрчлүүд илэрсэн байна.

Аргалант илч ОНӨААТҮГ-ын арилжааны банк дахь харилцахын оны эхний үлдэгдэл 10.2 мянган төгрөг, Аргалант сумын цахим худгийн усны төлбөрийн орлого 2,668.4 мянган төгрөгийг энэхүү дансанд төвлөрснөөр, нийт 2,678.6 мянган төгрөгийн үлдэгдэлд төлбөрийн акт тогтоож шийдвэрлэлээ.

Хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны зардлын 854.5 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардлыг эргэж төлөгдөх зээлээр буруу ангилан тайлагнасан зөрчил байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 498,844.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 172,259.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	45,533.9	47,782.1	2,248.2
Зээлийн хүүгийн авлага	0	0	0
Байгууллагаас авах авлага	78,378.1	166,146.4	87,768.3
Хувь хүмүүсээс авах авлага	202,672.4	284,915.6	82,243.2
Дүн	326,584.4	498,844.1	172,259.7

Эх сурвалж: Аргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга

Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 498,844.1 мянган төгрөгийн 57,1 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 33,3 хувийг байгууллагаас авах авлага, 9,6 хувийг ажиллагчидтай

холбогдсон авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 99,8 хувь буюу 284,585.6 мянган төгрөг нь Хоршоо хөгжүүлэх сангийн, байгууллагаас авах авлагын 21,8 хувь буюу 109,040.5 мянган төгрөгийн авлага нь ЗДТГ-н авлага 11,5 хувь буюу 56,800.0 мянган төгрөгийн авлага нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага байна.

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 11,046.1 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг нь тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажсан байна.

#### Аудитын илрүүлэлт:

1. Орон нутгийн төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд ( 27.24 м.кв, 29.14 м.кв 1 өрөө) 2 байр нийлүүлэх гэрээний 3-д заасны дагуу ажлын явцын тайлан, гэрээ дүгнэсэн баримтгүйгээр ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данснаас 1 болон 2 дахь шатны 80 хувийн санхүүжилтэд 80,000.0 мянган төгрөгийг гэрээ хийсэн иргэнд олгож, авлага нэмэгдсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

2. Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 5 жилээс дээш насжилттай, тооцоо нийлсэн актгүй, эзэн холбогдогч тодорхойгүй 330.0 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага дансны үлдэгдэл байгаа зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлсэн байна.

3. Засаг даргын нэгтгэсэн тайлангийн авлага дансны тодруулгад тооцоо нийлсэн байдал, насжилттай холбоотой 389,167.8 мянган төгрөгийн залруулга хийгдлээ.

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансанд үлдэгдэлгүй байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 116,662.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,799.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Түүхий эд материал</b>	<b>24,365.4</b>	<b>19,162.5</b>	<b>-5,202.9</b>
Тусгай зориулалттай материал	0		
Эм боох материал	24,365.4	19,162.5	-5,202.9
<b>Хангамжийн материал</b>	<b>85,997.4</b>	<b>93,999.8</b>	<b>8,002.4</b>
Бичиг хэргийн материал	3,394.4	3,457.8	63.4
Аж ахуйн материал	11,183.8	15,536.2	4,352.4
Сэлбэг хэрэгсэл	2,984.0	2,984.0	0
Түлш, шатах тослох материал	618.6	159.3	-459.2
Барилгын засварын материал	2,472.3	2,472.3	
Хүнсний материал	0		
Бусад хангамжийн материал	65,344.3	69,390.3	4,046.0
<b>Мал амьтад</b>	<b>3,500.0</b>	<b>3,500.0</b>	<b>0</b>
<b>Дүн</b>	<b>113,862.8</b>	<b>116,662.4</b>	<b>2,799.7</b>

Эх сурвалж: Аргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бараа материалын тодруулга

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 116,662.4 мянган төгрөгийн 81,5 хувийг буюу 95,115.6 мянган төгрөгийг ЗДТГ-ын бараа материал, 2 хувийг буюу 2,341.7 мянган төгрөгийг ИТХ-ын бараа материал, 16,5 хувийг буюу 19,205.0 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн бараа материал эзэлж байна.

Бараа материал дансны оны эхний үлдэгдэл 2,799.7 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын аж ахуйн материал болон бусад хангамжийн материал өссөн нь нөлөөлсөн.

Аудитын илрүүлэлт: ЗДТГ-т бараа материалын ангиллыг сайжруулах зөвлөмж өгөгдсөн байна.

### 3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,450,632.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 87,215.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Биет хөрөнгө</b>	<b>1,884,658.9</b>	<b>1,797,946.0</b>	<b>-86,712.9</b>
Барилга, байгууламж, орон сууц	1,457,423.3	1,370,853.4	-86,569.9
Авто-тээврийн хэрэгсэл	149,619.5	127,944.7	-21,674.7
Машин тоног төхөөрөмж(компьютер)	196,538.2	188,689.4	-7,848.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	33,193.9	28,186.3	-5,007.5
Бусад үндсэн хөрөнгө	47,884.0	82,272.06	34,388.1
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>653,188.7</b>	<b>652,686.3</b>	<b>-502.4</b>
Программ хангамж	954.7	452,311.9	-502.4
Бусад биет бус хөрөнгө	652,234.0	652,234.0	
<b>Дүн</b>	<b>2,537,847.6</b>	<b>2,450.632.3</b>	<b>-87,215.3</b>

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Аргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулга

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,7 хувь буюу 2,439,958.0 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,3 хувь буюу 7,130.7 мянган төгрөгийг ИТХ, 0,03 хувь буюу 3,543.6 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: ЗДТГ-ын эзэмшилд байгаа газрыг данс бүртгэлд бүрэн аваагүй, байгууллагын эзэмшилд байгаа тээврийн хэрэгслүүд ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй зөрчил байна.

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 11,046.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 5,896.5 мянган төгрөгөөр өссөн байна

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбоотой өр	0	0	0
Байгууллагад төлөх өр	5,149.6	11,046.1	5,896.5
<b>Дүн</b>	<b>5,149.6</b>	<b>11,046.1</b>	<b>5,896.5</b>

/ мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Аргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн өглөгийн тодруулга

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 11,046.1 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг нь тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажсан байна.

Өр төлбөрийн жилийн эцсийн үлдэгдлийн 46,2 хувь буюу 5,113.1 мянган төгрөг нь эмийн эргэлтийн сангийн, 32,2 хувь буюу 3,555.7 мянган төгрөг нь Ерөнхий боловсролын сургуулийн гэрэл цахилгааны өглөг, 11,1 хувь буюу 1,229.2 мянган төгрөг нь Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагад төлөх өглөг, 10,4 хувь буюу 1,148.1 мянган төгрөг нь Засаг даргын тамгын газрын байгууллагад төлөх өглөг эзэлж байна.

*Аудитын илрүүлэлт: Засаг даргын нэгтгэсэн тайлангийн өр төлбөр дансны тодруулгад тооцоо нийлсэн байдал, насжилттай холбоотой 4,640.8 мянган төгрөгийн залруулга хийгдлээ.*

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,659,917.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 223,996.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>1,385,745.2</b>	<b>1,385,745.2</b>	<b>0</b>
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,907,704.5</b>	<b>2,131,700.8</b>	<b>223,996.3</b>
Өмнөх үеийн үр дүн	4,053,749.3	1,897,945.9	-2,155,803.5
Тайлант үеийн үр дүн	-2,146,044.8	233,754.9	2,379,799.7
<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	<b>142,471.8</b>	<b>142,471.8</b>	<b>0</b>
<b>Дүн</b>	<b>3,435,921.6</b>	<b>3,659,917.8</b>	<b>223,996.3</b>

*Эх сурвалж: Аргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Энэ үзүүлэлт өмнөх оноос 223,996.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 233,754.9 мянган төгрөгөөс, хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн асcolous программд 12 зээлдэгчийн 9,758.6 мянган төгрөгийн буруу бүртгэсэн алдааг Монгол банкны мэдээлэлийн нэгдсэн сангийн мэдээлэл, өмнөх оны дансны И-хуулгатай тулгаж зөрүүг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр өмнөх үеийн үр дүнрүү бууруулах бичилт хийж залруулснаас шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Аргалант сумын төсвийн байгууллагуудын төсвийн төсөлд 2,283,596.0 мянган төгрөгийн орлого зардлын саналыг төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тусгай санхүүжилтийн 4 байгууллагуудын төсвийг салбар тус бүрийн төсвийн ерөнхийлөн захирагчаас санхүүжүүлэхээр шийдвэр гарсны дагуу төлөвлөгөөг 387,584.9 мянган төгрөгөөр бууруулж 331,007.1 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Аргалант сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг 287,782.1 мянган төгрөг, татварын бус орлогыг 167,051.3 мянган төгрөг, татварын буцаалтыг 17,000.0 мянган төгрөг, нийт татварын орлогыг 437,833.4 мянган төгрөгөөр, 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,270,233.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор сумын төсөвт төвлөрүүлэх нийт орлогыг 489,223.4 мянган төгрөгөөр, 2023 оны төсвийн жилд зарцуулах нийт зарлагыг 1,629,685.3 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 11-ны өдрийн “Аргалант сумын 2023 оны тодотгол батлах тухай” 01 дүгээр “Аргалант сумын 2023 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 288,176.5 мянган төгрөг, татварын бус

орлогыг 216,383.4 мянган төгрөг, татварын буцаалтыг 15,336.5 мянган төгрөг, нийт татварын орлогыг 489,223.4 мянган төгрөг, үйл ажиллагааны урсгал зардлыг 605,260.6 мянган төгрөг, тусгай санхүүжилтийн орон нутгийн 4 байгууллагын байр ашиглалтын тогтмол зардалд 331,007.1 мянган төгрөг, сумын төсвийн урьд оны шилжих үлдэгдлийн эх үүсвэрээр хийгдэх хөрөнгө оруулалт, их засварыг 261,953.4 мянган төгрөг, ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээг 205,110.5 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн зарлагыг 226,353.7 мянган төгрөг, нийт зарлагыг 1,629,685.3 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 25 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 489,223.4 мянган төгрөг, орон нутгийн төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 447,044.3 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг 173,969.8 мянган төгрөг, сумын ОНХС-ийн шилжих үлдэгдлээс 9,788.6 мянган төгрөг, 2023 оны малын тоо толгойн албан татвараас 21,352.1 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 261,953.4 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангаас 226,353.7 мянган төгрөг, нийт санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,629,685.3 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,338,792.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсөвт 42,149.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,293,296.4 мянган төгрөг буюу 79,4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 124,166.9 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	ИТХ-ын үндсэн үйл ажиллагаа	80,571.40	80,013.6	557.8	99.3%
2	ЗДТГ-ын үндсэн үйл ажиллагаа	524,689.20	438,419.7	86,269.5	83.6%
3	ЕБС-ийн тогтмол зардал	153,518.90	153,518.8	20.0	99.9%
4	Сургуулийн өмнөх боловсролын тогтмол зардал	56,741.50	55,708.8	1032.7	98.2%
5	ЭМТ-ийн тогтмол зардал	42,648.50	41,333.8	1,314.7	97.0%
6	Соёл урлагийн тогтмол зардал	78,098.20	74,293.2	3,804.9	95.1%
7	Хөрөнгийн зардал	693,417.6	450,008.3	243,409.4	65%
	Сумын дүн	1,629,685.3	1,293,296.2	335,376.3	79.4 %

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас 127,806.5 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 21,995.3 мянган төгрөг, нийт 149,801.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, ажиллагсад орон нутгийн нэмэгдэл олгох, төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөр, малын тооллого хийх, малын тэжээл бэлтгэх, ногоон өвс авах зэрэг ажлуудад 126,179.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 23,622.2 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Төв аймгийн Аргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас 11,785.7 мянган төгрөгийн орлогоос ажиллагсад орон нутгийн нэмэгдэл цалинг олгож, 300.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд нийт 161,587.5 мянган төгрөг төвлөрч, 137,665.3 мянган төгрөгийг зарцуулж, сумын Засаг даргын Тамгын газар нь 23,622.2 мянган төгрөг, ИТХ нь 300.0 мянган төгрөг, нийт 23.922.2 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105-Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	2023.01.01 2023.12.31	Нутгийн иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг илэрхийлэх, тэднийг төлөөлөх тухайн нутаг дэвсгэрийн нийгмийн амьдралын аливаа асуудлыг иргэдийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэж байх, ИТХ-ын хуралдааныг 2-оос доошгүй удаа, Тэргүүлэгчдийн хуралдааныг 12-оос доошгүй удаа хуралдуулах, гэмт хэрэг зөрчил гарахаас урьдчилан мэргийлэх Хууль эрх зүйн сургалт сурталчилгаа явуулах	Сумын ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгчид бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хурлын үйл ажиллагааг тасралтгүй мэдээллээр ханган хэвийн үйл ажиллагааг ханган явуулсан байна. Хэрэгжилт 100%	80,571.40	71,230.3
2	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг нийгмийн хөгжлийг төлөвлөх, хяналт шинжилгээ хийх үнэлэх, дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүйг туслалцаа үзүүлэх төрийн болон төрийн бус байгууллагуудын уялдааг хангахад туслах, байгаль орчинд учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хор хөнөөлийг арилгах	Төрийн бодлого шийдвэр хууль тогтоомжийг хэрэгжүүлэн сурталчилан таниулах үйл ажиллагааг явуулж төрийн албаны үйлчилгээг цаг алдалгүй иргэдэд хүргэж, иргэд, удирдлагуудыг мэдээлэлээр шуурхай үйлчилж ажилласан байна. Хэрэгжилт 85.99%	524,689.20	511,389.1
3	71802-Ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Хичээлийн жилд сурагчдын сурч боловсрох таатай орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллах	Дулаан, цахилгаанаар бүрэн хангасан Хэрэгжилт 100%	153,518.90	153,518.8
4	71801-Сургуулийн өмнөх	2023.01.01 2023.12.31	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүүхэд бүрт	Дулаан, цахилгаанаар	56,741.50	55,708.8

	боловсролын үйлчилгээ		хүргэж, зөв төлөвшил олгох	бүрэн хангасан Хэрэгжилт 100%		
5	71602-ЭМТ-ийн үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх	Дулаан, цахилгаанаар бүрэн хангасан Хэрэгжилт 100%	42,648.50	41,333.8
6	71702-Соёл урлагийн үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Сумын иргэдэд соёл урлаг спортын үйл ажиллагааг чанартай зохион байгуулах, соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, өвлүүлэх, уламжлах, нээн илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчилах	Дулаан, цахилгаанаар бүрэн хангасан Хэрэгжилт 100%	78,098.20	74,293.2
7	70106-сумын шилжих үлдэгдлийн эх үүсвэрээр хийгдэх Хөрөнгө оруулалт их засвар	2023.01.01 2023.12.31	Зам дагуух маяк, шатахуун ЗДТГ, мод тарих, хогийн цэгийн тэмдэг, Зөөврийн вагончиг, замын аспальт, спорт заалыг акустик хавтангаар доторлох, Аньдын худаг, гэрэлтүүлэг, ИТХ-ын хуралдааны танхимын тохижилт үйлчилгээ сайжруулалт хийх 10 төсөл арга хэмжээ	Шилжих үлдэгдлийн эх үүсвэрээр хийгдэх Хөрөнгө оруулалт их засварын ажлын Хэрэгжилт 63.6 %	261,953.4	166,644.4
8	70106- ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдэх Хөрөнгө оруулалт их засвар	2023.01.01 2023.12.31	Төв зам дагуух гэрэлтүүлэг ногоон байгууламж хашаа хийх, наадмын талбай тохижуулах, малчдад худаг гаргах 3 төсөл арга хэмжээ	ОНХСангийн төсөл хөтөлбөрөөс, Наадмын талбайг тохижуулах Флай Хай ХХК тендерт шалгарч ажил гүйцэтгэж 2023 оны эхний болон дунд шатны санхүүжилт-д 56800,0 мянган төгрөгийг шилжүүлж авлагаар тусгасан байна. Хэрэгжилт 27.7%	205,110.5	56,800.0
9	70106-Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01 2023.12.31	Хоршооны үйл ажиллагааг дэмжин ажиллах	Таримал тэжээл тарих, хорголжин малын тэжээлийн үйлдвэрийн өргөтгөл, үрийн будаа агуулах барих, бууз баншны цехийн 4 төсөлд нийт 160,000.0 мянган төгрөгийн зээл 4 иргэнд олгож, үйл ажиллагааны зардалд 854.5 мянган төгрөг зарцуулсан. Хэрэгжилт 71,1%	226,353.7	160,854.5

Хэрэгжилт нь дутуу болон хангалтгүй байгаа төсөл хөтөлбөрийн шалтгаан нөхцөл байдлын талаар авч үзэхэд:

Орон нутгийн хөгжлийн сангаас хийгдэх хөрөнгийн зардлын 82,904.5 мянган төгрөгийн Төв зам дагуух гэрэлтүүлэг, ногоон байгууламж хашаа хийх, 31,140.7 мянган төгрөгийн малчдад цахим худаг гаргах төсөл хөтөлбөрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлээгүй байна. Энэ нь малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө биелээгүй бөгөөд, төв зам дагуух гэрэлтүүлгийн ажлын тендерийг 6 удаа зарлахад тендерт оролцогч ороогүй, шилжих үлдэгдлээс зөөврийн сууц, зам дагуух хатуу хучилт, авто паркийн зураг төсөв, жишиг гудамж гэсэн ажлууд хийгдээгүй байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас сумын Засаг даргын 2023 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн А/73 захирамжаар таримал тэжээл тарихад 45,000.0 мянган төгрөг, хорголжин малын тэжээлийн үйлдвэрийн өргөтгөл хийхэд 50,000.0 мянган төгрөг, үрийн будаа агуулах барихад 50,000.0 мянган төгрөг, бууз баншны цехэд 15,000.0 мянган төгрөг, нийт 160,000.0 мянган төгрөгийн зээл 4 иргэнд олгож, үйл ажиллагааны зардалд 854.5 мянган төгрөг зарцуулсан байна. Сангийн журамд өөрчлөлт орсноор, хоршооны шалгуур үзүүлэлтийн шаардлагыг хангасан аж ахуйн нэгж байхгүй байгаагаас хэрэгжилт 71,1 хувьтай байна.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Төв аймгийн Аргалант сумын Засаг дарга нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нээлттэй 2 тендер, тендер шалгаруулалтын онцгой журмаар 9 тендерийг зарлаж, нэгдсэн хогийн цэгийг ландфиллийн аргаар булаах, эрүүл мэндийн төвд суудлын автомашин авах, ахуйн үйлчилгээний байрны гадна фасад, дээврийн засвар болон сантехникийн засвар сайжруулалтын ажил, уурын зуухны гадна фасадыг засварлаж өвс тэжээлийн фонд болгох зэрэг бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Ерөнхий гэрээгээр худалдан авалт хийгдээгүй байна. Энэ нь цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараа, ажил үйлчилгээний сонголт бага, өртөг зардал өндөр байгаа тул өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, шууд худалдан авалт хийж гэрээ байгуулан ажилласан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/12 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын нэгтгэсэн тайлангийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны төсвийг, суурь үзүүлэлтээр нийт зарлага 1,270,233.5 мянган төгрөгийг сонгосон.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 19,053.5 мянган төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Ажлын баримтад материаллаг байдлын суурь үзүүлэлт, хувь хэмжээг сонгосон шалтгаан, тайлбар болон материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзэх шалтгаан, тайлбарыг тусгасан болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 14,290.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласнаар төсвийн жилийн хүрээнд 6 орон тоо дутуу ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 3,742.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 11,777.1 мянган төгрөг, бусад урсгал зардлаас 4,480.2 мянган төгрөг, нийт 20,000.2 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Аргалант сумын ЗДТГ, ИТХ гэсэн байгууллагууд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг зөрчиж төсвийн хөрөнгөөр биеийн тамирын хувцас 1,080.0 мянган төгрөгөөр худалдан авсан, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг хэрэгжүүлэлгүй байгууллагын эзэмшилд байгаа тээврийн хэрэгслүүд ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй зөрчилтэй асуудалд зөвлөмж өгөгдсөн байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын шилэн дансны цахим хуудсанд тайлант онд байршуулбал зохих 157 мэдээллээс 139 мэдээллийг хугацаандаа байршуулж, 16 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийн хугацаа болоогүй төлөвт байна. Тендер шалгаруулсан, худалдан авах ажиллагаатай холбоотой 71.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 1,583,522.9 мянган төгрөгийн 12 мэдээлэл, зарлагын 385,226.5 мянган төгрөгийн 12 мэдээлэл, төсөв өмч хөрөнгөтэй холбоотой 213,207.9 мянган төгрөгийн 15 шийдвэр байршуулсан бөгөөд хугацаа хоцролт 68,8 хувьтай, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 94.8 хувьтай байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчил байхгүй байна. Энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 7.3-д харуулав.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдэж, 4 зөвлөмж өгөгдсөн бөгөөд хэрэгжилтийг аудитаар дахин горим сорил хэрэгжүүлж, аудитын тайланд тусгасан

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 төлбөрийн акт, орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 01/97 тоотой хэрэгжилтийг ирүүлж, fas.audit.mn системд бүрэн оруулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	9,050.5	2	9,050.5	100%
Албан шаардлага					
Зөвлөмж	1	35,338.2	1	35,338.2	100%
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>44,388.7</b>	<b>3</b>	<b>44,388.7</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Аргалант сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудлаар дараах асуудлыг тодорхойлж байна. Үүнд:

- ОНХС-г төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагаа, сумын иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, зарцуулалттай холбоотой асуудал

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

#### Залруулсан алдаа

Аудитаар 393,808.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нэгтгэсэн тайлангийн авлага дансны тодруулгад 389,167.8 мянган төгрөг, өглөг дансны тодруулгад 4,640.8 мянган төгрөг, нийт 393,808.6 мянган төгрөгийн тооцоо нийлсэн байдал, өглөг авлагын насжилттай холбоотой алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4-д “үнэн зөв байх” зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “толилуулга”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу аудитын явцад залрууллаа.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн 6.1-д харуулав.

Аудитаар 3,008.6 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>2</sup> илэрсний 2,678.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 330.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

## 5.1 Төлбөрийн акт

Аудитаар Аргалант сумын нэгтгэсэн тайлангаар 2,678.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

1.Аргалант сумын ИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 01 тогтоолоор татан буугдсан Аргалант илч ОНӨААТҮГ-ын арилжааны банк дахь харилцахын оны эхний 10.2 мянган төгрөгийн үлдэгдэл дээр Аргалант сумын цахим худгийн усны төлбөрийн орлого 2,668.4 мянган төгрөг энэхүү дансанд нэмж төвлөрсөн байна. (Цахим худгийн орлого төвлөрүүлдэг байсан эрх нь дуусгавар болж татан буугдсан Аргалант илч ОНӨААТҮГ-ын энэхүү харилцах дансыг хааж, эцсийн үлдэгдэл 2,678.6 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.)

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.”, 23 дугаар зүйлийн 23.3-д “Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээслэсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3-д “Орон нутгийн өмчийн хувьчлалын орлогыг тухайн орон нутгийн төсөвт оруулна” заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “ангилал”, “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.4-д “төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

Төлбөрийн акт тогтоогдсон зөрчлийг байгууллага тус бүрээр энэ нэгтгэсэн тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 7.2-д харуулав.

## 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдсөн асуудал байхгүй байна.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Үр ашгийг дээшлүүлэхтэй холбоотой асуудал

#### 1.1. Илрүүлэлт:

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Тус байгууллага тайлант онд төсвийн орлогод нийт дүнгээр 717.419.0 мянган төгрөг орж 140.5 хувиар хувиар биелүүлсэн боловч, орон нутагт төвлөрүүлэх 5 нэр төрлийн орлого тасарсан, улсын төсөвт төвлөрүүлэх орлогод 4.316.8 мянган төгрөг төвлөрүүлж, 42.9 хувиар биелүүлж, 2 нэр төрлийн орлого тасарсан, улсын төсөвт төвлөрүүлэх орлогод 4.316.8 мянган төгрөг төвлөрүүлж, 42,9 хувийн биелэлттэй бөгөөд 2 нэр төрлийн орлого тасарсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Бүх шатны төсвийн орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр болон нэр төрлөөр биелүүлэх.

## **2. Төлөвлөлт. Хяналт, удирдлагыг сайжруулахтай асуудал**

### 2.1. Илрүүлэлт:

Орон нутгийн ерөнхий орлогын дансанд 5 жилээс дээш насжилттай, тооцоо нийлсэн актгүй, эзэн холбогдогч тодорхойгүй 330.0 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага дансны үлдэгдэл байгаа зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-д "үнэн зөв байх", 5.1.5-д "Хариуцлагатай байх" зарчмыг баримтлаагүй, 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "толилуулга", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Авлагыг бүрэн барагдуулах

Аудитаар Аргалант сумын нэгтгэсэн тайлангийн 330.0 мянган төгрөгийн 3 зөрчил, ЗДТГ-ын 30,261.9 мянган төгрөгийн 5 зөрчил, ХХС-гийн 854.5 мянган төгрөгийн 1 зөрчил, нийт 31,446.4 мянган төгрөгийн 9 зөрчилд зөвлөмж өгч, зөрчлийг байгууллага тус бүрээр энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл 7.2-д харуулав.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д " Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ." заалтын дагуу хүргүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг дарга	1	1			1			
2	Засаг даргын тамгын газар	1	1				1		
3	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
4	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
5	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
6	Эмийн эргэлтийн сан	1		1					
	<b>НИЙТ</b>	<b>6</b>	<b>2</b>	<b>4</b>		<b>1</b>	<b>1</b>		

## 7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 7.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	51,425.9	1	1,148.1	1	50,277.8	2	51,425.9				
ИТХ	2	11,136.3	1	1,495.2	1	9,641.1	2	11,136.3				
ОНХС	0	0					0	0				
ХХС	0	0					0	0				
ОНЕО	1	393,808.6			1	393,808.6	1	393,808.6				
ЭЭС	0	0					0	0				
Дүн	5	456,370.8	2	2,643.3	3	453,727.5	5	456,370.8		0		0

### 7.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

